



## Өндөрцагааны ховор металт грейзен ордын геологи, эрдсийн найрлага

**Б. Тамир<sup>1\*</sup>, Д. Доржготов<sup>2</sup>, Ю. Туяацэцэг<sup>2</sup>**

*МУИС-ШУС, Геологи-Геофизикийн тэнхим<sup>1</sup>  
Адамас Майнинг ХХК<sup>2</sup>*

### ABSTRACT

Undurtsagaan ore deposit is located within the intrusive dome developed by Berkhan fault zone at the northwest area of Devonian overlapped depression called as Kherlen. Geologic setting of the deposit is dominantly characterized by silicified and clay schist, quartz-sericite schist of Tsargiin gol formation and gabbro and diabase dikes occurring mostly comfortable with the schist but rarely crossing them. The central part of the deposit is intruded by leucogranite stock-like body. As a result, uppermost granite and overlying terrigenous rocks are subjected to a lot of cracks to cause greisen alteration and rare metal ore formation. The rare metal greisen appears as oval-shaped stockwork with NW-extension of 1500m in length and 1000m in width. The veins and veinlets found within the greisen are dominant of quartz-tungsten, quartz-tungsten-molibdenite, and quartz-beryl in composition as well as have great value of extraction. Since the ore forming processes consisted of subsequent events, the ore is very complex in composition. According to the result of mineralographic and petrographic analysis, there are identified approximately 70 minerals mostly including W, Mo and Be. No survey into the depth has been conducted, yet. W and Mo reserves might be increased by further detailed exploration.

**Keywords:** Dome, composition, formation, fault, deposit, metasomatic, greisen, stockwork.

\*Corresponding author. Tel.: +976-99052065

E-mail address: tamir1201@num.edu.mn

### Оршил

Өндөрцагааны ховор металын орд нь Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын нутагт Улаанбаатар хотоос зүүн зүгт 310 км, аймгийн төвөөс баруунхойш 80 км, Өмнөдэлгэрsumaас зүүн зүгт 30 км-ийн здтай оршдог. Энд хамгийн өндөр цэг нь Өндөрцагаан уул 1680 м-т байрладаг. Ордын геологийн судалгаа, эрэл-хайгуулын ажил нь манай улсын нийгэм-эдийн засгийн хоёр өөр тогтолцоог дамнан судлагдсан олборлоход дөхөж очсон ордуудын нэг юм.

1979 оноос Өндөрцагааны хүдрийн талбайд эрэл-үнэлгэний ажил хийх зорилгоор Олон улсын геологийн экспедицийн харьцаа Монгол-Болгарын хамтарсан хайгуулын ангийг зохион байгуулж уул-өрмийн, геофизикийн, геохимийн болон бусад аргуудыг хослуулан хэрэглэж эрэл, эрэл-үнэлгээний судалгаа хийжээ.

1980-1982 онд Өндөрцагааны орд дээр урьдчилсан хайгуулын ажил хийгдсэнээр түүнийг

интрузив биетийн дээд ба оройн хэсэгт үүссэн грейзен дэх молибден-берилл-вольфрамын штокверк төрлийн орд болохыг тогтоосны зэрэгцээ хүдрийн ба металын нөөцийг C<sub>1</sub> болон C<sub>2</sub> зэрэглэлээр тооцоолжээ. 2005-2007 онуудад Т.Намсрай нар Кью Жи Экс Монгол компанийн өрөмдсөн цооногууд болон 1979-1982 оны хооронд хийгдсэн эрэл үнэлгээ, урьдчилсан хайгуулын үеийн бүх судалганы үр дүнг нэгтгэн боловсруулж ордын нөөцийн тооцоог дахин хийж үнэлгээ өгчээ.

1983-1989 онуудад Өндөрцагааны хүдрийн талбайд байрладаг Мөнгөн-Өндөрийн орд дээр эрэл-үнэлгээний ажлыг хийж нөөцийг C<sub>2</sub> ба P<sub>1</sub> зэрэглэлээр тооцоолсон (Василев нар, 1990) байна. 2008-2009 онуудад Голден хейлс компани ордын 1 ба 3-р хүдрийн бүсүүд дээр нарийвчилсан хайгуул хийж (Доржготов нар, 2010) нөөцийг В, С, P<sub>1</sub> зэрэглэлээр тооцоолжээ.

Дээрхи ажлуудын үр дүнг нэгтгэн боловсруулж энэ өгүүлийг бичив.



Зур.1. Өндөрцагаан ордын гадаргын төрх байдал

### Ордын хүдрийн талбайн геологийн тогтоц

Өндөрцагааны молибден-вольфрамын орд нь Хэрлэнгийн гэж нэрлэгдсэн девоны үеийн тэнгисийн давхацмал хотгорын зүүн-хойд захын хэсэгт Бэрхийн хөндлиен хагарлын нөлөөллийн бүсэд байрладаг. Ордын хүдрийн талбайн геологийн тогтоц нь харьцангуй энгийн бөгөөд зонхиулж доод девоны Царигийнгол формацийн метатунамал чулуулаг, нийцлэгээр байрласан габброидын диабазын жижиг биетүүдээс бурдсан.

### Давхаргазүй

Царигийнгол формаци нь хоёр мэмбэртэй. Ордын хүдрийн талбайд дээд мэмбэрийн шаварлаг занар, алевролит зонхиулж тархсан хааяа жижиг мөхлөгт элсжин, филлитийн нарийн үеүүд тохиолддог.


Шаварлаг занар нь зүсэлтийн доод хэсэгт маш их тархалттай. Түүний үеуд нь 10м хүргэл зузаантай. Цооногийн дээжинд тэр нь хар саарал өнгөтэй, ан цавшилд бага орсон, занарлаг текстуртэй, микролепидогранобласт, алевролитлаг структуртай, ихэнх тохиолдолд региональ метаморфизмд өртөж серицитжсэн, хлоритжсон байдаг.

Түүний эрдсийн найрлагад хлорит, серицит, шаварлаг эрдсүүд 40-50%, кварц 10-20%, биотит, хээрийн жонш, мусковит, циркон, гранат, апатит орсон. Найрлагад нь зонхиулж орсон эрдсүүдээс хамаарч шаварлаг занарыг дотор нь серицитэт, кварц-мусковит-биотитот, хлорит-сериицитэт, кварц-

сериицитэт гэж ангилж болно. Занар дотор нилээд хэмжээгээр пиритийн үеллэг маягийн судланцууд ажиглагддаг ба тэр нь занартай сингенетик үүсэлтэй байж магадгүй.

Элсжин нь жижиг, хааяа дунд мөхлөгтэй, цул үеллэг текстуртэй, саарал, шаргалдуу, ногоовтор хүрэн, хүрэн өнгөтэй. Элсжин нь алевролит, занартай салаавчлан байрласан 15см-ээс хэдэн метр хүргэл зузаантай үе үүсгэсэн байдаг ба заагийн хэсэг нь аажим шилжилтэй учир алевроэлсжин, элсжинлэг занар зэрэг завсарын төрөлтэй. Элсжин нь кварц-сериицитийн найрлагатай материалыаар цементлиздсэн, кварц /40-50%/, хээрийн жонш /20-25%/, хлорит, мусковит, биотит болон занарын хэмхдсээс бүрджээ. Тэр нь зонхиулж бластопсамитлэг, псамитлэг структуртэй.

Алевролит нь дээрхи чулуулагтай салаавчлан байрласан үеүүдийг үүсгэсэн байх ба тэр нь хар саарал, хар хүрэн өнгөтэй, занарлаг-үеллэг текстуртэй, алевролитлог структуртэй, зонхиулж кварц, хээрийн жонш, хлорит, серицитээс бурдсан. Түүний үндсэн хэсэг нь кварцтай шаварлаг материалыаас тогтсон байна. Царгийн гол формацийн давхаргазүйн хил зааг талбайн хэмжээнд сайн тогтоогдоогүй. Формацийн зүсэлтийн хамгийн их зузаан нь 1200 м гэж тогтоожээ (Подстольски нар, 1979). Формацийн геологийн нас нь эртний амьтны үзүүлэгдлийн (брахиопод, криноид) тодорхойлтоор доод девон (Модзалевская, 1977) гэж тогтоогдсон.



### Таних тэмдэг

Q <sub>IY</sub>	Алюви, алюви-пролювийн хурдас: Хайрга, хайрганцар, элс, уйрмэг, сайрга	Геологийн хил
D <sub>1</sub> cr <sub>2</sub>	Царигийнгол формац. Дээд мэмбэр шаварлаг занар, алевролит, хааяа элжин, филлит	Тектоник эвдрэл: а. Тогтоогдсон б. Таамагласан
D <sub>2</sub>	Доод-дунд девоны интрузив: Габбро, габбродиабаз, диабаз, микродиорит	Байрлалын элемент
	Шаварлаг занар, филлит	Мөнгөн-Өндөрийн ордын мөнгө-холимог металлын хүдэржилтийн хил
	Цахиурлаг занар	Өндөрцагааны ордын ховор металт грейзений хил
	Кварцит, элжин	
	Аркоз элжин	

Зур. 2. Өндөрцагааны хүдрийн талбайн геологийн зураг (Калафут нар 1978)

### Интрузив чулуулаг

Ордын хүдрийн талбайн гадаргад илэрсэн интрузив чулуулаг нь Царигийнгол формацын чулуулагтай нийцлэг хааяа түүнийг зуссан байрлалтай, габбро, габбродиабаз, диабаз, микродиорит, микродиорит порфиритийн олон жижиг силл, дайк хэлбэрийн биетүүдээс бүрдсэн. Габбродиабаз нь ногоовтор, бараан саарал ногоон онготэй дунд, том ширхэгтэй ба хил заагийн орчимдоо жижиг ширхэгтэй болж хувирсан. Габбройд нь 2км хүртэл урттай, 500м хүртэл

өргөнтэй, ихэнх тохиолдолд хлоритжсоин, лимонитжсон, эпидотжсон байна. Тэдгээр биетүүдийн нас сайн тогтоогдоогүй учир зарим судлаачид доод девоны настай гэж үздэг бол зарим нь юрын настай (Мөнгөн-Өндөрийн ордын талбайд) гэж үздэг. Судлаачдын үзэл баримтлалыг харьцуулан үзэхэд Хэрлэнгийн хотгор дахь габбройд нь хоёр өөр насных байх магадлал өндөр байгаа тул цаашид нарийвчлан судлах шаардлагатай.

Өндөрцагааны ховор металт грейзен ордын гүнд үссэн шүлтлэгдүү найрлагатай лейкоборжингийн

шток маягийн биет нь шалгалтын цооногоор 440м гүнээс эхлэн огтлогдсон. Тэр нь грейзенжсэн, ховор металын эрдэжилттэй. Лейкоборжингоос авсан гурван сорыц дахь мусковитэд K-Ar аргаар хийсэн судалгаагаар түүний үнэмлэхүй нас 179-192 сая жил (Болгарын геологийн институт) гэж тогтоогджээ.

### Ордын структур

Өндөрцагааны ордын хүдрийн штокверк нь интрузив биетийн дээрхи бүнхэр структур ба түүний хагарал ан цавуудал үүссэн. Штокверкийн хэмжээнд босоодуу байрлалтай, баруун хойш чиглэлтэй хагарлын систем эрчимтэй хөгжсөн. Харин өргөрөг, уртрагийн дагуу ба зүүн-хойш чиглэсэн хагарлууд сулавтар хөгжсөн байна. Дээрх хагаралууд олон дахин идэвхжиж сэргэсний нөлөөгөөр бүнхэр структурийн дээд, оройн хэсэгт их хэмжээний ан цавшил / кливаж / бий болж тэр нь флюид нэвчиж, хүдрийн судланцууд ба шигтгээнүүд үүсэн тогтох орчныг бүрдүүлжээ гэж үзэж болно. Ордын төв хэсэгт уртрагийн дагуу чиглэлтэй сброс-сдвиг төрлийн нэг хагарал тогтоогдсон ба түүгээр орд нь баруун ба зүүн блокууд болон хуваагдаж улмаар баруун блок сууж, зүүн блок өргөгдсөн байна.

### Ордын агуулагч чулуулгийн хувирал

Өндөрцагааны ордын хүдрийн талбай дахь агуулагч чулуулаг нь метасоматоз процесст эрчимтэй өртөгдсөний улмаас дараах найрлагатай грейзен буюу метасоматит үүсчээ. Үүнд:

а. кварц-мусковит-биотитийн найрлагатай метасоматит

б. кварц-мусковитийн найрлагатай метасоматит

в. кварц-молибденит-бериллийн найрлагатай метасоматит

Кварц-мусковит-биотитын метасоматит нь штокверкийн хэмжээнд маш өргөн тархалттай. Энэ нь бараавтар саарал онгтгэй, микрогранобласт структуртай, занарлаг текстуртай жижиг ширхэгтэй. Найрлагад нь кварц 5-80%, биотит 20%, мусковит 10%, серицит 5% хүртэл, хээрийн жонш 10% хүртэл агуулгатай орсон.

Кварц-мусковитын метасоматит нь штокверкийн захын ба төвийн хэсгээр үүссэн ба түүний эрдсийн бүрэлдэхүүн нь дээрхтэй үндсэндээ адил, онцлог нь серицит, мусковит давамгайлсанаас болж цайвар онгтгэй ажиглагддаг.


Хүдрийн судлын мусковитэд K-Ar аргаар хийсэн шинжилгээгээр хүдэр үүслийн үнэмлэхүй нас 175+6 сая жил гэж тогтоогджээ. Ордын хүдэржилт, хувирал нь гүнд орших боржингийн биеттэй орон зай, цаг хугацааны хувьд нягт холбоотой нь харагдаж байна.



Зур.3. Ховор металт кварц-биотитын найрлагатай метасоматит. (q- кварц, be -берилл, fl-флюорит, mu-мусковит, wf-вольфрамит, mb-молибденит)



Зур.4. Кварц-бериллийн хялгасан судал (q- кварц, be - берилл)



Зур.5. Кварц-берилл-молибденитийн судал. (q- кварц, be- берилл, mb-молибденит)

## Хүдрийн биетийн тогтоц ба хүдрийн найрлага

Орд нь баруун хойшоо чиглэлтэй, 1800-1200 м урттай, 600-800 м өргөнтэй газрын гадаргад баруун хойш сунасан зууван дугуй хэлбэртэй гүн рүүгээ 650 м хүртэл үргэлжилсэн штокверк маягийн биетээс бүрдсэн. Штокверкын доторхи хүдрийн судланцууд 1мм-ээс хэдэн см зузаантай, 1 т.метрт 25-35 ширхэг хүдрийн судланцар ажиглагддаг. Штокверкын хялласан судлууд нь зонхилж кварц-вольфрамитын, кварц-молибденитын, кварц-берильтопазын, кварц-мусковит-берильтын найрлагатай. Штокверкын төв хэсэгт вольфрамит, берилл, захын хэсэгт сульфид агуулсан судланцар зонхилдог. Минералогийн судалгаагаар ордод 70 гаруй эрдэс тогтоогдсон ба тэдгээрийн дотроос хүдрийн гол эрдэс нь вольфрамит, молибденит, берилл юм.

Вольфрамит нь кварцын судланцууд ба судал орчмын грейзенд тохиолддог бөгөөд вольфрамын үйлдвэрийн ач холбогдолтой хүдрийн 75% орчмыг бүрдүүлнэ. Вольфрамит нь маш жижиг /2-9мм/ хавтанлаг, призмлэг, зүүлэг, зөв бус хэлбэрийн талст байдлаар ажиглагддаг. Судалгаагаар вольфрамит нь 3 генерацаар (Журавлева нар, 1990) үүсчээ. 1-р генерацийн вольфрамит маш ховоор грейзен дотор тохиолддог бол 2-р генерацийн вольфрамит кварцын судал, грейзенд их тархалттай, хүдэр үүсгэгч гол эрдэс бөгөөд кварц, гялтгануур молибденит, сульфидуудтай хам ассоциац үүсгэдэг. Вольфрамитын химийн шинжилгээгээр  $WO_3$ -75.6%, Mn-5.1%, FeO-19.5% агуулгатай тул ферберитэд хамруулж болно. 3-р генерацийн вольфрамит зонхилж кварц-хээрийн жоншны ба кварц-хоёр гялтгануурт судланцуудад хааяа ажиглагддаг.

Молибденит тархалтаараа 2-рт ордог хүдрийн гол эрдэс бөгөөд 2 генерацаар үүсчээ. 1-р генерацаын молибденит нь ихэвчлэн кварцын судланцуудад, ховоор грейзенд тохиолддог бол 2-р генерацийн молибденит судланцуудын гадаад зааг хэсгийн метасоматит дотор хааяа ажиглагддаг байна.

Кварц-молибденитын судланцууд молибденийн үйлдвэрлэлийн ач холбогдолтой хүдрийн ихэнх хувийг бүрдүүлдэг. Цагаан өнгийн кварц, хуудаслаг молибденит хам ургал үүсгэсэн байх ба хүдрийн судланцарын зааг орчимд өргөн хөгжсон байна. Заримдаа 2 см хүртэл диаметртэй бөөгнөрөл үүсгэнэ. Химийн найрлагад нь холыц байдлаар Fe->0.1%, Cu-0.01%, Pb-0.002%, Zn-0.001%, Ag-0.001-0.005% агуулгатай оржээ. Ордын гүн рүү кварц-молибденитын судланцууд ихсэх хандлагатай байхад кварц-вольфрамитын судланцуудын тоо хэмжээ бараг өөрчлөгдхөгүй.

Кварц-берильтопазын судал, судланцууд нь штокверк биетийн төв хэсгээр зонхилж үүссэн. Берилл нь өнгөгүй, ногоон, шаравтар ногоон, цэнхэр өнгөтэй бөгөөд хамгийн өргөн тархалттай нь

өнгөгүй берилл юм. Ногоон ба цэнхэр берилл голдуу флюориттэй хамт цацраг маягийн ургалт үүсгэсэн.

Судланцууд дахь кварцын оромд хийсэн шинжилгээгээр  $340^{\circ}$ - $445^{\circ}$  температурт хүдэр үүссэн (Ковачев нар, 1990) гэж тогтоогджээ.

Дээрхи хүдрийн гол эрдсүүдээс гадна рутил, ильменит, пирротин, арсенопирит харьцангуй элбэг тохиолддог.

## Дүгнэлт

Өндөрцагааны ховор металт грейзений орд нь интрузивийн дээрх бүнхэр структурт лейкоборжинтой холбоотой үүссэн. Лейкоборжингийн үнэмлэхүй нас /179-192 сая жил/ хүдэржилтийн үнэмлэхүй нас / 175+-6 сая жил / ойролцоо тул орон зай, цаг хугацааны хувьд тэдгээр нь хоорондоо нягт холбоотой байна.

Хүдрийн биет нь грейзен дэх зуувандуу дугуй хэлбэртэй штокверк бөгөөд хүдэр агуулсан судланцууд нь зонхилж кварц-берильтын, кварц-вольфрамитын ба кварц-молибденитийн найрлагатай. Үйлдвэрийн ач холбогдолтой хүдэр нь кварц-вольфрамит ба кварц-молибденит. Хүдрийн гол эрдэс нь вольфрамит, молибденит юм.

Хүдэр үүслийн процесс олон үе шатаар явагдсан байх тул хүдрийн гол эрдсүүд олон генерацитай. Ордын гүний судалгаа бараг хийгдээгүй тул цаашид гүний хайгуул хийж нооц өсгөх боломжтой.

## Ашигласан хэвлэл

Журавлева Л. Н., Чеботарева Н. А., 1990. Вещественный состав и особенности оруденения комплексного месторождения Ундуру-Цагаан. В кн: Геология и полезные ископаемые МНР. Вып. II, М., Недра, с. 109-116  
Нафтали.Л.Ж., Волков.В., Консулов.Ц., Райнов.С., 1984 Геохимическая зональность Ундуру цаганского рудного поля по вторичным ореолам рассеивания. В кн: Геология и полезные ископаемые МНР. Вып. II, М., Недра, с. 102-108

Ковач А., Грин Г. 1980. Новые данные по абсолютному возрасту интрузивных образований Северо-Керуленской зоны Восточной Монголии, В.кн.: Геология и полезные ископаемые МНР, Вып. I, М., с. 109-115

Сүх-Эрдэнэ Ж., Өндөрцагааны ховор металын ордын хүдэржилтийн онцлог, бакалаврын эрдэм шинжилгээний ажил, УБ., 2014

Васильев В и др. Отчет о результатах поисково-разведочных работ на комплексном рудопроявлении вольфрама на Ундуруцаган в Хэнтэйском аймаке Северо-восточной Монголии (партия №14 и 20)

Калафут М и др, Геологическое строение и полезные ископаемые района месторождения Ундуруцаган-обо в Северо-восточной Монголии (Отчет о результатах поисково-съемочных работ масштаба 1:50000 партии №6), Тайллан 2935/

Консулов. Ц. и др, Отчет о результатах предварительной разведки, проведенной партией № 28 МГЭ в 1982 г. на штокверке "Ундуруцаган"-Хэнтэйский аймак МНР, том I, II, 1983 г., Тайллан 3612/

Доржготов Д., Авиэрэд С. нар, Монгон-Өндөрний монгэ-холимог металын ордод 2008-2009 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дунгийн тайллан, УБ., 2009 он

Намерай Т., Даваасамбуу Д. нар, Өндөрцагааны вольфрам-молибдений үндэсн ордод 1982, 2005-2007 онуудал гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дунгийн тайллан, УБ., 2007 он